



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 1/17

Арвайхээр

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, 30, 31, 75 дугаар зүйлүүд, Татварын ерөнхий газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 02/1255 дугаар чиглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Татварын албаны чиг үүргийг хэрэгжүүлэх татвар төлөгчид зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх, татвар төлөгчийн хууль тогтоомжийг сайн дураар даган мөрдүүлэх стратегийг хэрэгжүүлэх, татвар төлөгчийн тайлагнасан тайланг хуулийн хугацаанд баталгаажуулах, засварлуулах, хугацаандаа төлөөгүй татварын өр, ногдолын дутууг хурааж улс, орон нутгийн төсвийн татварын орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааны тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлж ажиллахыг хариуцсан татварын улсын байцаагч нарт даалгасугай.
3. Төлөвлөгөөний хэрэгжилтийг тухай бүр хэлтсийн даргад тайлагнаж, танилцуулахыг тасгийн дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТУР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Н.ЭРДЭНЭСУВД

ИЮА0056
1116128578

9044027

Өвөрхангай аймгийн Татварын хэлтсийн
даргын 2022 оны 06 сарын 06-ны өдрийн
дугаар тушаалын хавсралт

ИЮА0056
1116128578

1 9044927

МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ,
ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛИЙН 28.1, 30, 31, 75 ДУГААР ЗҮЙЛД ЗААСАН ТАТВАРЫН АЛБАНЫ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ,
ТАТВАР ТӨЛӨГЧИД ЗӨВЛӨГӨӨ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ, ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ САЙН ДУРААР ДАГАН
МӨРДҮҮЛЭХ СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ТАЙЛАГНАСАН ТАЙЛАНГ ХУУЛИЙН ХУГАЦААНД
БАТАЛГААЖУУЛАХ, ЗАСВАРЛУУЛАХ, ХУГАЦААНДАА ТӨЛӨӨГҮЙ ТАТВАРЫН ӨР, НОГДЛЫН ДУТУУГ ХУРААЖ УЛС, ОРОН
НУТГИЙН ТӨСВИЙН ТАТВАРЫН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ЖИГД ХАНГАН БИЕЛҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тайлан, мэдээ явуулах хугацаа	Хариуцах албан хаагч	Хяналт тавих албан тушаалтан
Нэг: Том, дунд, жижиг; бичил, бичил-иргэн ангиллын татвар төлөгчдийн татварын хууль тогтоомжийн мөрдөлтийг сайжруулан үйлчилгээнд суурилсан татвар хураах үйл ажиллагааг хэрэгжүүлж, татварын ерийг хураах				
1.1	Хуулийн татвараа төлдөг татвар төлөгч /ХТМТ-1/-ийн хууль даган мөрдөлтийг хэвээр хадгалахтай холбоотой татварын өр үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, сургалт, сурталчилгааг эдийн засгийн салбарын ангиллаар сар бүр тогтмол зохион байгуулах, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлсэн байх;	Хагас, бүтэн жилээр	Ц.Даваасүрэн Л.Буюнжаргал П.Орхонтуул Д.Нансалмаа	Сегментийн тасгийн дарга нар
1.1.1	Хэлтсийн тусгай төлөвлөгөөний дагуу хийх	Хагас, бүтэн жилээр	Ц.Даваасүрэн Л.Буюнжаргал	Сегментийн тасгийн дарга нар
1.2	Татварын 5.0 сая төгрөгөөс доош тайлант оны дутуу үлдэгдэлтэй, жижиг, бичил, бичил-иргэн ангиллын татвар төлөгчийн татвар төлөх хуулийн хугацаа 1-12 сараар хэтэрсэн /ХТМТ-Н/ түвшинд хамаарах татвар төлөгчид татвар хураах албадлага хэрэглэхгүй, хугацаандаа татвараа төлөөгүйгээс үүсэх эрсдэлээс хамгаалах, цахим татвар хураалтыг хэрэгжүүлэх (масс мессеж, масс мэйл илгээх, дуудлагаар өр хураах);	Хагас, бүтэн жилээр	Д.Болор-Эрдэнэ Я.Наранчимэг	Сегментийн тасгийн дарга нар

1.2.1	Масс мессэж илгээх татвар төлөгчдийн үнэн зөв утасны дугаартай жагсаалт гаргах	2022.06.15	Д.Болор-Эрдэнэ Я.Наранчимэг	Сегментийн тасгийн дарга нар
1.2.2	2021 оны дутуу төлсөн МТТАТ төлөгчдийн үнэн зөв утасны дугаартай жагсаалтыг гаргах	2022.06.15	Хариуцсан сум, багаараа бүх байцаач нар	Сегментийн тасгийн дарга нар
1.2.3	Масс мессэж илгээх	2022.06.15-20	Ц.Даваасүрэн Л.Буюнжаргал	Сегментийн тасгийн дарга нар
1.3	Жижиг, бичил, бичил-иргэн ангиллын татвар төлөгчдийн тайлант оны (2022 он) ногдол үүссэн тухай бүр Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд үүссэн "Төлберийн нэхэмжлэх"-ийг татвар төлөгчийн бүртгэлтэй цахим хаягаар хүргүүлэх, татварын өр үүсгэхгүй байх татвар хураалтыг хэрэгжүүлснээр тайлант оны ногдлын барагдуулалтыг сар бүр 6.7%-иар, хяналт шалгалтын ногдлын барагдуулалтыг 5%-иар тус тус нэмэгдүүлж, жилийн эцэст тайлангийн барагдуулалт 80-оос доошгүй, хяналт шалгалтын барагдуулалт 60-аас доошгүй хувьд хүргэсэн байх;	Хагас, бүтэн жилээр	Сегментийн тасгийн дарга нар	Хэлтсийн дарга
1.3.1	Мэйл явуулах үнэн зөв хаяг бүхий татвар төлөгчдийн жагсаалт гаргаж, бичиг хэрэгт өгөх	2022.06.15-20	Д.Болор-Эрдэнэ Я.Наранчимэг Д.Нансалмаа	Сегментийн тасгийн дарга нар
1.3.2	Мэйл явуулах	2022.06.20 2022.10.10-20	Д.Отгонтuya	А.Ганчимэг
1.4	Татвар төлөх хуулийн хугацаа 2-4 жил хэтэрсэн, санхүүгийн эргэлтийн хөрөнгө дутмагаас татвараас төлж чадахгүй /ХТМТ-Ш/ түвшинд хамаарах татвар төлөгчийг авлага, өглөг, төлберийн чадвар, санхүүгийн тайлангийн шинжилгээгээр тодорхойлж, TEX-ийн 19-24 дүгээр зүйлд заасан нийтлэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх, мөн TEX-ийн 27 дугаар зүйлд заасан харилцан хамаарлыг тогтоон өмнөх оны татварын тайлангийн өрийн барагдуулалтыг сар бүр 11.5%-иар, хяналт шалгалтын өрийн барагдуулалтыг 8.5%-иар тус тус нэмэгдүүлж, жилийн эцэст тайлангийн барагдуулалт 70%-иас доошгүй, хяналт	Хагас, бүтэн жилээр	Сегментийн тасгийн дарга нар	Хэлтсийн дарга

	шалгалтын барагдуулалт 50%- иас доошгүй хувьд хүргэсэн байх;			
1.4.1	Татвар төлөгчдийн жагсаалт гаргах	2022.06.15	Д.Болор-Эрдэнэ Р.Наранчууун П.Орхонтуул	
1.4.2	Хяналт шалгалтын өрийн жагсаалт гаргаж, олон жил дамнасан өрийг барагдуулах, жагсаалтад орсон татвар төлөгчид стандарт түвшинд барагдсан байх	Хагас, бүтэн жилээр	Т.Бадамхорол Сегментийн тасгийн тухайн ТТ-ийг хариуцсан ажилтан	
1.4.3	Татварын өр стандарт түвшинд барагдсан байх, тасаг бүрээр	Хагас, бүтэн жилээр	Сегментийн тасгийн дарга нар	Хэлтсийн дарга
1.5	Татвараас зайлс хийдэг, өрийн наскилт 4-өөс дээш жил болсон, татварын өрөө төлөх талаар татварын албатай тохирсон амлалт, хуваарийн дагуу татвараа төлдөггүй (хугацааны хөнгөлөлт) зэрэг шалтгаанаар /ХТМТ-1V/ түвшинд хамаарах татвар төлөгчөөс сар бүр 10-20 татвар төлөгчид TEX-ийн 27, 59 дүгээр зүйлд заасны дагуу харилцан хамаарал, эд хөрөнгийн байдал, татвар төлөх үүрэгтэй хоёрдогч этгээдтэй эсэхийг тодорхойлох, татварын өр хураах үйл ажиллагааг TEX-ийн 58 дугаар зүйлд заасны дагуу хэрэгжүүлэх, улмаар TEX-ийн 60, 62, 63, 64, 65, 66, 67, 68 дугаар зүйлд заасан гүйцэтгэлийн бие даасан эрх мэдлийг хэрэгжүүлснээр өрийн үлдэгдлийн барагдуулалтыг өмнөх сарын түвшингөөс 2.5%- иар, жилийн эцэст 30%-иас доошгүй хувиар тус тус нэмэгдүүлэх	Хагас, бүтэн жилээр	Сегментийн тасгийн дарга нар	Хэлтсийн дарга
1.5.1	Хүндрэлтэй, 4-өөс дээш жилийн наскилттай татвар төлөгчдийн жагсаалт гаргах	2022.06.10	П.Орхонтуул Д.Болор-Эрдэнэ С.Оюун-Эрдэнэ	
1.5.2	Хүндрэлтэй, 4-өөс дээш жилийн наскилттай ТТ-өөс Шүүхэд шилжүүлэх татвар төлөгчидтэй ажиллах	2022.06.30	Б.Бямбасүрэн	А.Ганчимэг
1.5.3	Хөрөнгө шилжик ирсэн, өөрийн биеэр ирдэггүй татвар төлөгчдийн өр барагдуулах шат дараалсан арга хэмжээ авах	2022.06.10	Б.Бямбасүрэн, хариуцсан ТУБ	А.Ганчимэг

1.5.4	Дээрх заалтуудын дагуу арга хэмжээ авч, стандарт түвшинд хүргэх	Хагас, бүтэн жилээр	Б.Бямбасүрэн Сегментийн тасгийн дарга нар	А.Ганчимэг
1.6	Улсын төсвийн татварын өрийн үлдэгдлийн 56%-ийг нэмэгдсэн өртгийн албан татварын өр эзэлж байгаа тул сар бүр 500.0 сая төгрөгөөс дээш дүнтэй ногдолтой тайланд шинжилгээ хийж, ногдлын үнэн зөв байдлыг тодорхойлох, алдаатай үүссэн ногдлыг тухай бүр татвар төлөгчөөр засварлуулах, сар бүрийн тайлангийн үнэн зөв байдлыг харьяа нэгж хариуцах;	Дараа сарын 06-ны дотор tamir.t@mta.gov.mn	Сегментийн тасгийн дарга нар	С.Дашхорол
1.7	Эзэн холбогдогч нь нас барсан, дампуурсанд тооцож татан буугдсан, татвар төлөгчдийн татварын өрийг хүчингүй болгосон, бууруулсан тухай шүүхийн шийдвэр гарсан, Татварын ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлд заасан татвар төлөх үүрэг дуусгавар болох, бусдад шилжих харилцааг 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 09/939 дугаар албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу хэрэгжүүлэх; (Хуулийн мэргэжилтэнтэй хамтрах);	Дараа сарын 06-ны дотор tamir.t@mta.gov.mn	Б.Бямбасүрэн	А.Ганчимэг
1.8	Татвар төлөгчөөс нөхөн ногдуулалтын акт, шийтгэлийн хуудсаа хүлээн зөвшөөрөөгүй Маргаан таслах зөвлөл болон шүүхэд хандсан татварын хяналт шалгалтын татварын өрийг хураах үйл ажиллагааг 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 09/816 дугаар албан бичгээр өгсөн чиглэлийн дагуу хэрэгжүүлэх; (Хяналт шалгалтын нэгжтэй болон хуулийн мэргэжилтэнтэй хамтрах);	Дараа сарын 06-ны дотор tamir.t@mta.gov.mn	Т.Бадамхорол Б.Бямбасүрэн Д.Нансалмаа	Хэлтсийн дарга
1.9	ШШГА-аас шилжиж ирсэн болон албадан гүйцэтгэх ажиллагаанд байгаа татвар төлөгчийн өрийг Татварын ерөнхий хуулийн 54 дүгээр зүйлд заасан зохицуулалтыг баримтлан эрсдэлтэй татварыг урьдчилан хураах үйл ажиллагааг хэрэгжүүлэх;	Дараа сарын 06-ны дотор tamir.t@mta.gov.mn	Б.Бямбасүрэн Сегментийн тасгийн дарга нар	А.Ганчимэг
Хоёр: Улс, орон нутгийн төсвийн татварын орлогыг төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх				
2.1	Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, Татварын ерөнхий газрын даргын 2022 оны А/49 дугаар тушаалаар баталсан улсын төсвийн татварын орлогын төлөвлөгөөний сар, улирлын хуваарь, орон нутгийн		Бүх байцаагч нар Сегментийн тасгийн дарга нар	Хэлтсийн дарга

	иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр батлагдсан орон нутгийн төсвийн татварын орлогын төлөвлөгөөний хуваарийн дагуу улс, орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг төсвийн ангилал, татварын нэр төрлөөр жигд ханган биелүүлэх;			
2.1.1	Орлогын төлөвлөгөөг төрөл тус бүрээр, сар бүрээр, байцаагч бүрээр гарган, тасаг тасгаараа нэгтгэн гаргаж, сарын ажлын үнэлгээнд тусгах	Дараа сарын ажлын эхний өдөр	Сегментийн тасгийн дарга нар	Хэлтсийн дарга
2.2	Аймгийн татварын хэлтэс нь улсын болон орон нутгийн төсвийн татварын орлогын төлөвлөгөө биелээгүй шалтгааныг сар бүр татварын төрөл тус бүрээр тогтоон дүн шинжилгээ хийж, танилцуулга (текстэн) бэлтгэн дараа сарын 6-ны дотор Татвар хураалтын удирдлага, арга зүйн газарт ируулэх;	Дараа сарын 06-ны дотор urtnasan.b@mta.gov.mn	Сегментийн тасгийн дарга нар	Хэлтсийн дарга
2.2.1	Тухайн сарын тасарсан орлогын шалтгааныг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэх, шалтгааныг тайлбарлах	Дараа сарын ажлын эхний өдөр	Сегментийн тасгийн дарга нар	

Гурав: Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

3.1	Галт зэвсэг, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, ногдол нь Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх эрх бүхий байгууллагын мэдээллээс зөрүүтэй бол ноглох баримтыг баримтжуулан, бүртгэл, ногдлын өөрчлөлтийг тухай бүр бүртгэх;	2022.09.30-ны дотор munkhnasan.b@mta.gov.mn , urtnasan.b@mta.gov.mn	3.Түмэндэмбэрэл Б.Батдолгор П.Орхонтуул	Ц.Цэнд-Аюуш
3.1.1	Татварт бүртгэлгүй буу эзэмшигчдийн жагсаалт гаргах	2022.06.05	Б.Батдолгор	Ц.Цэнд-Аюуш
3.1.2	Нэмж ТҮНС-д бүртгэх шаардлагатай эсэхийг сумдаас санал авах, бүртгэхгүй бол шалтгааныг жагсаалтын ард тодорхой бичих	2022.06.15	3.Түмэндэмбэрэл	Ц.Цэнд-Аюуш
3.1.3	Нэмж ТҮНС-д бүртгэх шаардлагатай эсэхийг Арвайхээр харьяаллын иргэдийхийг тодруулах, бүртгэхгүй бол шалтгааныг жагсаалтын ард тодорхой бичих	2022.06.15	Б.Батдолгор	Ц.Цэнд-Аюуш
3.1.4	Бүртгэл хийх	2022.06.30	Б.Батдолгор 3.Түмэндэмбэрэл	Ц.Цэнд-Аюуш
3.2	Татварын бүртгэл, мэдээллийн санд 5-аас дээш жилийн насжилттай 30,371 галт зэвсэг (нийт ногдол 514.5 сая.төг), 52,285 үл хөдлөх эд хөрөнгө (нийт ногдол 44.4 тэрбум.төг) байгаа тул шалтгааныг тодруулж бүртгэл, ногдлын өөрчлөлтийг тухай бүр бүртгэх;	2022.09.30-ны дотор munkhnasan.b@mta.gov.mn , urtnasan.b@mta.gov.mn	3.Түмэндэмбэрэл Б.Батдолгор П.Орхонтуул	Ц.Цэнд-Аюуш

3.2.1	Татвар төлөгч бүрээр гаргах	2022.06.05	Б.Батдолгор /Арвайхээр/ 3.Түмэндэмбэрэл /сумд гаргах/ Д.Нансалмаа /Хархорин сум/	Сегментийн тасгийн дарга нар
3.2.2	Шалтгааныг тодруулж бүртгэл, ногдлын өөрчлөлтийг тухай бүр бүртгэх;	2022.09.30	Б.Батдолгор /Арвайхээр/ 3.Түмэндэмбэрэл /сумд гаргах/ Д.Нансалмаа /Хархорин сум/	Сегментийн тасгийн дарга нар
3.3	Ус бохирдуулсны төлбөрийн 122 татвар төлөгчийн дүгнэлт, Томоохон эх үүсвэрийн агаарын бохирдлын төлбөрийн 49 татвар төлөгчийн мэдээллийг харьялах татварын албадад цахим хаягаар хүргүүлсэн. Илгээсэн дүгнэлт, мэдээллийг үндэслэн татвар төлөгчдөд мэдээллийг хүргүүлж холбогдох хуулийн дагуу бүрэн тайллагнуулж, тесэвт төвлөрүүлэх.	2022.09.30-ны дотор munkhnasan.b@mta.gov.mn , urtnasan.b@mta.gov.mn	Сегментийн тасгийн дарга нар	
3.4	Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллээр тусгай хамгаалалттай газар нутаг дэвсгэрт 5,275 этгээд газар ашиглаж буй мэдээлэл байгаа боловч Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас улсын тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглагч 4,953 нэгж талбар бүртгэлтэй байгаа талаар мэдэгдсэн тул холбогдох мэдээллийн зөрүүг арилгах талаар орон нутгийн газрын асуудал хариуцсан төрийн захирагааны байгууллагатай хамтран газар ашиглаж буй төлбөр төлөгчийн бүртгэл, ногдол, төлөлт, үлдэгдлийг тулгах ажлыг зохион байгуулах;	2022.09.30-ны дотор munkhnasan.b@mta.gov.mn , urtnasan.b@mta.gov.mn	Б.Бямбасүрэн Д.Нансалмаа	Ц.Цэнд-Аюуш
Дөрөв: Тайлан хүлээн авч баталгаажуулах, засварлуулах талаар				
4.1	2021 оны жилийн эцсийн тайлан, 2022 оны 1-р улирлын тайлан баталгаажуулалтын байдлыг хянан үзэхэд татварын алба татвар төлөгчийн тайланг хянан баталгаажуулж хүлээн аваагүй 2021 оны 35,746 тайлан, 2022.01-р улирлын 38,130 тайлан байна. Татвар төлөгчийн илгээсэн тайланг Татварын ерөнхий хуулийн 30.2-т заасны дагуу хянан мэдээллийн зөрүү илрэсэн	2022.06.30-ны дотор ttug@mta.gov.mn	М.Бямбасүрэн Р.Наранчуулун Д.Нансалмаа Ц.Энх-амгалан	С.Дашхорол

	тохиолдолд мөн хуулийн 30.4-д заасныг баримтлан татварын албаны шаардлагыг хүргүүлэн, хуулийн 30.5, 30.6, 30.7-д заалтыг хэрэгжүүлэн тайланг хүлээн авч баталгаажуулах /Судалгааг хавсаргав/;		
4.2	2021 оны Хувь хүний орлогын албан татварын жилийн эцсийн тайлангаар хуулийн 15 дугаар зүйлийн 15.6, 15.7-д заасан шаардлага хангагүй хялбаршуулсан горимоор тайлан ирүүлсэн 152 иргэнийг тайланг засварлуулах /Судалгааг хавсаргав/;	2022.06.30-ны дотор ttug@mta.gov.mn	М.Бямбасүрэн С.С.Уранцэцэг Д.Нансалмаа Ц.Энх-амгалан С.Дашхорол